



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 40 (469)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай
(шинэчилсэн найруулга)*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Тогтоолд өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны аравдугаар сарын 26

№40 (469)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

623.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай (шинэчилсэн найруулга)	1173
624.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	1181
625.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	1181

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

626.	Хуулийн төслүүдийг буцаах тухай	Дугаар 82	1182
------	---------------------------------	-----------	------

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

627.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 214	1182
------	--	------------	------

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

628.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 196	1188
------	---------------------------------	------------	------

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, төсвөөс буцаан олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль¹, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Иргэн, хуулийн этгээдийн импортолсон буюу экспортолсон бараа, түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахад энэ хууль үйлчилнэ.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "борлуулалт" гэж барааг бусдын өмчлөлд төлбөртэйгээр шилжүүлэх, ажил, үйлчилгээг төлбөртэйгээр гүйцэтгэхийг;

¹ Татварын ерөнхий хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

4.1.2. "бараа" гэж мөнгөн хөрөнгөнөөс бусад бүх төрлийн эд хөрөнгийг;

4.1.3. "нэгдсэн дугаар бүхий нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, тэдгээрийн нэгжийн болон нийт үнэ, түүнчлэн нэмэгдсэн өртгийн албан татварын хэмжээг тусгасан, татварын албанаас олгосон нэгдсэн дугаар бүхий нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичгийг;

4.1.4. "аж ахуйн үйл ажиллагаа" гэж ашиг олох зорилготой болон тийм зорилгогүй, бүхэлд нь буюу хэсэгчлэн бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

4.1.5. "иргэн" гэж Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалагчгүй хүнийг;

4.1.6. "байнга оршин суугч, оршин суугч бус" гэж Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6, 7 дугаар зүйлд заасан ойлголтыг;

4.1.7. "хуулийн этгээд" гэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлж, мөн хуулийн 17.4-т зааснаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ авсан этгээдийг;

4.1.8. "үйлчилгээ" гэж бараа борлуулах, мөнгөн гүйлгээ хийхээс бусад аливаа үйл ажиллагааг;

4.1.9. "орон сууцны зориулалтаар ашиглагдаж байгаа орон байр" гэж орон сууцны зориулалтаар ашиглалтад оруулсан бөгөөд энэ хуулийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах барилгыг;

4.1.10. "нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болсон өдөр" гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхэлж орлого олж байгаа иргэн, хуулийн этгээдийн үг үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ хуулийн этгээдийн орлогын албан татварын тайлангаар, эсхүл иргэний орлого, татвар тодорхойлох хуудсаар 10.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн өдрийн дараа сарын эхний өдрийг;

4.1.11. "гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар авсан бараа" гэж давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшгийн улмаас учирсан зохирлыг арилгахад зориулсан, түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээний дагуу болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийн байгууллагаас хариу төлбөргүйгээр хүлээн авсан барааг;

4.2. Энэ зүйлийн 4.1.11 дэх заалтад буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд гадаад улсын Засгийн газар, олон улсын болон

буяны байгууллагаас өгсөн санхүүжилт /мөнгөн хөрөнгө/-ээр дотоодын зах зээлээс худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээ нэгэн адил хамаарна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Албан татвар тологч, түүнийг бүртгэх, бүртгэлээс хасах

5 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар тологч

5.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа импортлосон болон экспортлосон этгээд, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байна.

5.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын хэмжээ нь 10 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн гадаадын хуулийн этгээдийн төлөөний газарт энэ зүйлийн 5.1 дэх заалт нэгэн адил үйлчилнэ.

5.3. Хөдөлмөрийн гэрээгээр байнга болон түр хугацаагаар ажиллаж байгаа иргэнийг нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчид тооцохгүй бөгөөд түүнд олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, тэтгэвэр тэтгэмж, шагнал урамшилд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй.

6 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах

6.1. Энэ хуулийн 4.1.10-т заасан нөхцөл хангасан этгээд ажлын 3 хоногт багтаан нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх өргөдлөө харьяалах татварын албанд гаргана.

6.2. Харьяалах татварын алба нь энэ хуулийн 7.1.3 дугаар зүйлд зааснаас бусад энэ хуулийн 4.1.10-т заасан этгээдийн өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдөрт багтаан нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэж, тухайн этгээдэд гэрчилгээ олгоно.

6.3. Энэ хуулийн 6.2-т заасан гэрчилгээний загварыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална.

6.4. Дараахь нөхцлийг хангасан тохиолдолд иргэн, хуулийн этгээд сайн дураараа нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж болно:

6.4.1. нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох үндсэн үйлдвэрлэл, ажил,

¹ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль - Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2003 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

үйлчилгээний борлуулалтын орлогын хэмжээ нь энэ хуулийн 4.1.10-т заасан орлогын 80 хувьд хүрсэн;

6.4.2.үндсэн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого энэ хуулийн 6.4.1-д заасан хэмжээнд хүрсэн эсэхээс үл хамааран Монгол Улсад 2.0 сая ам. доллар ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн.

6.5.Энэ хуулийн 6.4-т заасан орлого болон хөрөнгө оруулалт нь сүүлийн нэг жилд тухайн иргэн, хуулийн этгээдийн орлого, татвар тодорхойлох хуудас болон орлогын албан татварын тайлангаар нотлогдсон байхаас гадна уг этгээд нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай³ хууль, олон улсын стандартын дагуу хөтөлж хэвшсэн байвал зохино.

6.6.Сайн дураараа нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх тухай өргөдөл гаргах болон гэрчилгээ олгоход энэ хуулийн 6.1 болон 6.2-т заасан хугацаа нэгэн адил хамаарна.

6.7.Хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн эд хөрөнгө буюу саналын эрхийн 66-аас дээш хувийг нэг буюу хэд хэдэн хуулийн этгээд эзэмшиж байвал тэдгээрийг нэг бүлэг болгон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэж болох боловч ийнхүү нэг бүлэгт хамрагдсан хуулийн этгээд тус бүр нь энэ хуульд заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байна.

6.8.Энэ хуулийн 6.7-д заасны дагуу нэг бүлэг болж бүртгүүлэх зөвшөөрлийг харьяалах татварын албанаас бичгээр авна.

6.9.Энэ хуулийн 6.7-д заасны дагуу бүртгүүлсэн этгээдийн аль нэг нь тухайн бүлгийн нэрийн өмнөөс нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн үүрэг хүлээж, харьяалах татварын албатай харилцана.

6.10.Энэ хуулийн 6.7-д заасан этгээд тус бүр нь нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоо хийж, татварын тайлан тушаах шаардлагагүй боловч нягтлан бодох бүртгэлийг хуульд заасны дагуу хөтөлж, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн хувьд өөрт хамаарах асуудлаар эцсийн хариуцлага хүлээнэ.

6.11.Иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлснээс хойшхи нэг жилийн хугацаанд тэдгээрийн албан татвар ногдох орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрээгүй нь хуулийн этгээдийн хувьд орлогын албан татварын тайлангаар, иргэний хувьд орлого, татвар тодорхойлох хуудсаар нотлогдсон бөгөөд дараагийн жилүүдэд уг орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрэхгүй нөхцөлд харьяалах татварын алба

нь түүнийг албан татвар төлөгчийн бүртгэлээс хасч, гэрчилгээг хураан авна.

6.12.Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн болон уг бүртгэлээс хасагдсан иргэн, хуулийн этгээдийн нэрсийн жагсаалтыг Үндэсний татварын ерөнхий газар сар бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим сүлжээний вэб хуудсаар улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ.

6.13.Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн бүртгэлээс хасагдсан нь тухайн этгээдийг уг татварыг төлөгч байхдаа явуулсан үйл ажиллагааны төлөө нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн дагуу хүлээлгэх хариуцлагаас чөлөөлөх болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр шинээр бүртгүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээ

7 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээ

7.1.Хуульд өөрөөр заагаагүй бол дор дурдсан бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулна:

7.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа;

7.1.2.худалдах, хэрэглэх буюу ашиглах зориулалтаар Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаад улсад экспортолсон бүх төрлийн бараа;

7.1.3. худалдах, хэрэглэх буюу ашиглах зориулалтаар гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт импортолсон бүх төрлийн бараа;

7.1.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ.

7.2. Монгол Улсад байрладаггүй гадаадын хуулийн этгээд, түүнчлэн оршин суугч бус хувь хүний Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнийн дүн 10.0 сая төгрөг ба түүнээс дээш байвал энэ хуулийн 7.1.4 дэх заалт нэгэн адил хамаарна.

7.3. Дор дурдсан үйл ажиллагааг "бараа борлуулсан" -д хамааруулна:

7.3.1.аж ахуйн болон тодорхой бизнес эрхлэх эрхийг борлуулах;

7.3.2.татвар төлөгч нь худалдаа, үйлдвэрлэл, ажил, үйлчилгээгээ зогсоож, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн бүртгэлээс хасагдах үед бизнесийн хөрөнгөөс өөртөө бараа үлдээх;

³ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 4 дүгээрт нийтлэгдсэн.

7.3.3. бараанд энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу албан татварын хасалт хийх;

7.3.4. өрийн төлбөрийг бараа шилжүүлэх замаар хаах;

7.3.5. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугч бус хувь хүн Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн захиалгаар бараа борлуулах.

7.4. Дор дурдсан үйл ажиллагааг "үйлчилгээ үзүүлсэн"-д хамааруулна:

7.4.1. цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, шуудан, харилцаа холбооны болон бусад үйлчилгээ үзүүлэх;

7.4.2. бараа түрээслүүлэх буюу бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах;

7.4.3. зочид буудал буюу түүнтэй адилтгах байранд байр түрээслүүлэх буюу бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах;

7.4.4. байшин, барилгад байр түрээслүүлэх буюу бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах;

7.4.5. байшин, барилгаас бусад үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө түрээслүүлэх буюу бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах;

7.4.6. шинэ бүтээл, бүтээгдхүүний загвар, ашигтай загвар, зохиогчийн эрхэд хамаарах бүтээл, барааны тэмдэг, ноу-хау, хөрөнгийн мэдээллийг шилжүүлэх, түрээслүүлэх, худалдах;

7.4.7. эд мөнгөний хонжворт сугалаа гаргах, төлбөрт таавар, бооцоот тоглоом тоглуулах, зуучлагчийн үйлчилгээ үзүүлэх;

7.4.8. өрийн төлбөрийг ажил, үйлчилгээ үзүүлэх замаар хаах;

7.4.9. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугч бус хувь хүнээс Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн захиалгаар ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх;

7.4.10. буруутай үйл ажиллагааны улмаас бусдад хүү, торгууль төлөх;

7.4.11. ажил, үйлчилгээнд энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу татварын хасалт хийх.

7.5. Энэ хуулийн 7.1-д заасан бараа, ажил, үйлчилгээнд татвар ногдуулахад дор дурдсан нөхцөлийг хангасан байна:

7.5.1. тухайн этгээд нь энэ хуулийн 5, 6 дугаар зүйлд заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байх;

7.5.2. борлуулалтыг аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд хийсэн байх.

7.6. Энэ хуулийн 7.5.1 дэх заалтад мөн хуулийн 7.3.5, 7.4.9 дэх заалт хамаарахгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулах журам

8 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах

8.1. Нэмэгдсэн өртгийн албан татварыг дор дурдсан журмаар ногдуулна:

8.1.1. бараа, ажил, үйлчилгээг импортлолсон буюу экспортлолсон, түүнчлэн борлуулсан бол тухай бүрт;

8.1.2. барилга угсралтын ажил гүйцэтгэсэн бол эцсийн борлуулалтад;

8.1.3. санхүүгийн түрээсийн зүйлийг худалдан авсан буюу импортлолсон бол түрээсийн төлбөр хийхээр тохирсон хуваарийг баримтлан тухай бүрт.

8.2. Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан орлогод албан татвар ногдуулах, мөн хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу уг албан татвараас чөлөөлөхдөө "Эдийн засгийн бус төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ыг баримтална.

8.3. Энэ хуулийн 8.2-т заасан "Ангилал"-ыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээ

9.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг дор дурдсан журмаар тодорхойлно:

9.1.1. импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг Монгол Улсын Гаалийн тарифын тухай хуульд заасны дагуу тодорхойлсон гаалийн үнэ дээр гаалийн албан татвар, онцгой болон бусад албан татварыг нэмж;

9.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн болон борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг тэдгээрийн тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн;

9.1.3. Энэ хуулийн 7.3.1, 7.3.2-т заасан үйл ажиллагаанд нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг тэдгээр бараа, ажил, үйлчилгээний тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн;

9.1.4. эд мөнгөний хонжворт сугалаа, төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйлчилгээ эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг оролцогчдын төлсөн нийт мөнгөн дүнгээс хожлын төлбөрт төлсөн мөнгөний хэмжээг хасч;

9.1.5. өрийн төлбөрийг бараа шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх замаар барагдуулсан бол үнийнх нь дүнгээр.

* Гаалийн тарифын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 9 дүгээрт нийтлэгдсэн.

9.2. Дараахь тохиолдолд нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг харьяалах татварын алба тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн тодорхойлно:

9.2.1. борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнэ тариф тодорхойгүй;

9.2.2. бараа, ажил, үйлчилгээг харилцан солилцсон;

9.2.3. харилцан хамаарал бүхий этгээдүүд үнэгүй, эсхүл зах зээлийнхээс хямд буюу өндөр үнэ, тарифаар хоорондоо бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн.

9.3. Нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг гадаад валютаар хийсэн бол түүнийг энэ хуулийн 10.2-т зааснаар тогтоосон өдрийн Монголбанкны ханшийг үндэслэн төгрөгт шилжүүлнэ.

10 дугаар зүйл. Албан татвар ногдуулах хугацаа

10.1. Албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн орлогод нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулж эхлэх хугацааг татварын албанаас гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн тооцно.

10.2. Бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрт нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах хугацааг дор дурдсан үйлдлийн аль түрүүнд хийгдсэн өдрөөр тогтооно:

10.2.1. борлуулагч энэ хуулийн 4.1.3-т заасан падаан үйлдсэн өдөр;

10.2.2. борлуулагч худалдсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг хүлээн авсан өдөр;

10.2.3. бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан өдөр.

10.3. Цахилгаан, дулаан, хий, усан хангамж, шуудан, харилцаа холбооны болон бусад тогтмол үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах хугацааг энэ хуулийн 4.1.3-т заасан падаан бичсэн буюу төлбөрийг хүлээн авсан өдрийн аль түрүүнд хийгдсэнээр нь тогтооно.

10.4. Энэ хуулийн 7.3.2-т заасан бараанд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах хугацааг тухайн барааг өөртөө үлдээсэн өдрөөр тогтооно.

10.5. Бараа импортлолсон бол уг барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдрөөр нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах хугацааг тогтооно.

10.6. Жижиглэнгийн худалдаа эрхлэгч сард нэг удаа, бөөний худалдаа эрхлэгч борлуулалт хийх бүрдээ энэ хуулийн 4.1.3-т заасан падаан бичнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ

11 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах хувь

11.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нэмэгдсэн өртгийн албан татварыг импортлолсон болон үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний албан татвар тооцох үнэлгээний 10 хувиар ногдуулна.

11.2. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан бараа, ажил, үйлчилгээнд ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татварын хувь тэг /0%/ -тэй тэнцүү байна.

12 дугаар зүйл. Албан татварын тэг /0%/ хувь, хэмжээг хэрэглэх

12.1. Экспортод гаргасан дараахь бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тэг хувь /0%/ -тай тэнцүү байна:

12.1.1. худалдах зориулалтаар Монгол Улсын нутаг дэвсгэрээс экспортод гаргасан бөгөөд гаалийн байгууллагад мэдүүлсэн бараа;

12.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаад улсад, гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсын нутгаар дамжуулан бусад улсад гаргасан зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ;

12.1.3. гадаад улсад үзүүлсэн /албан татвараас чөлөөлсөн үйлчилгээг оролцуулан/ үйлчилгээ;

12.1.4. үйлчилгээ үзүүлэх үед Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаагүй гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээ /түүний дотор албан татвараас чөлөөлсөн үйлчилгээг оролцуулан/;

12.1.5. олон улсын нислэг үйлдэж буй дотоодын болон гадаадын агаарын тээврийн хөлөгт үзүүлэх нислэгийн хөдөлгөөний удирдлага, техникийн болон шатахууны үйлчилгээ, цэвэрлэгээ, нислэгийн явцад нисэх бүрэлдэхүүнд болон зорчигчдод худалдаа, хоол, ундаагаар үйлчилсэн үйлчилгээ;

12.1.6. Засгийн газар, Монголбанкны захиалгаар дотоодод үйлдвэрлэсэн төрийн одон медаль, зоос.

12.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хөдлөх, үл хөдлөх хөрөнгөтэй шууд холбоотойгоор үзүүлсэн үйлчилгээнд мөн хуулийн 12.1.4. дэх заалт хамаарахгүй.

12.3. Энэ хуулийн 12.1 дэх заалт нь гадаадын иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан

гэрээний үндсэн дээр экспортын үйл ажиллагаа эрхэлж байгаа, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдэд хамаарна.

12.4.Энэ хуулийн 12.1.4-т заасан иргэн, хуулийн этгээдийг дор дурдсан тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаагүй гэж үзнэ:

12.4.1. тухайн улсдаа төлөөний газартай боловч Монгол Улсад төлөөний газаргүй;

12.4.2. тухайн улсад төлөөний газаргүй бөгөөд уг этгээд нь Монгол Улсаас өөр улсад байнга оршин суудаг буюу байрладаг;

12.4.3. тухайн улс болон Монгол Улсын аль алинд нь төлөөний газартай боловч уг үйлчилгээ нь гадаад улс дахь төлөөний газрын хэрэгцээнд бүхэлдээ буюу ихэвчлэн зориулагдсан.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх

13 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.

13.1.Дараахь барааг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө:

13.1.1.гаалийн байгууллагаас баталсан, зорчигчдод татваргүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хэмжээ бүхий зорчигчдын биедээ авч яваа хувийн хэрэглээний бараа;

13.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэсний байгууллага түүний төрөлжсөн салбарын хэрэгцээнд зориулан импортолсон бараа;

13.1.3.Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагчдын хувийн хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээг тухайн улсад албан татвараас чөлөөлдөг бол тэр улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагчдын хувийн хэрэгцээнд зориулж Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ;

13.1.4.гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжаар авсан бараа;

13.1.5.хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл;

13.1.6.зэвсэгт хүчин, цагдаа, улсын аюулгүй байдлыг хангах, шүүхийн шийдеэр биелүүлэх байгууллагын хэрэгцээнд зориулан импортоор авч байгаа зэвсэг, тусгай техник хэрэгсэл;

13.1.7.иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг, түүний сэлбэг;

13.1.8.орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байр буюу түүний хэсгийг борлуулсны орлого;

13.1.9.газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах талаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тос хайх, олборлох, ашиглах үйл ажиллагаанд зориулан импортолсон техник, тоног төхөөрөмж, материал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, автобензин, дизелийн түлш;

13.1.10.эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэн;

13.1.11.хийн түлш, түүний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, механизм, техник, хэрэгсэл, тоноглол;

13.1.12.гадаад улсад захиалгаар хийлгэсэн Монгол Улсын мөнгөн тэмдэгт;

13.1.13.борлуулсан алт;

13.1.14.борлуулсан сонин.

13.2.Энэ хуулийн 13.1.11-д хамаарах барааны жагсаалтыг Засгийн газар батална.

13.3.Арван мянган төгрөгөөс доош үнэтэй бараа, ажил, үйлчилгээг нэг удаа худалдан авахад энэ хуулийн 13.1.3 дахь заалт хамаарахгүй.

13.4.Тусгай зориулалтын бус автомашин худалдан авахад энэ хуулийн 13.1.6 дахь заалт хамаарахгүй.

13.5.Худалдах зориулалтаар шинээр барьсан орон сууцны зориулалттай байр, түүний хэсэгт энэ хуулийн 13.1.8 дахь заалт үйлчлэхгүй.

13.6.Дараахь үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө:

13.6.1. валют солих үйлчилгээ;

13.6.2.мөнгө хүлээн авах, шилжүүлэх, баталгаа, төлбөрийн нөхэмжлэл гаргах, вексель, хадгаламжийн данстай холбогдсон банкны үйлчилгээ;

13.6.3.даатгал, давхар даатгал, эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ;

13.6.4.үнэт цаас, хувьцаа гаргах, шилжүүлэх, хүлээн авах, тэдгээрт баталгаа гаргах үйлчилгээ;

13.6.5.урьдчилгаа, зээл олгох үйлчилгээ;

13.6.6.нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсны хүүг олгох, шилжүүлэх үйлчилгээ;

13.6.7.банкны болон санхүүгийн түрээсийн хүү, ногдол ашиг, зээлийн баталгааны хураамж, даатгалын гэрээний хураамж төлөх үйлчилгээ;

13.6.8.орон сууцны зориулалтаар баригдсан байр болон түүний тодорхой хэсгийг түрээслэх үйлчилгээ;



13.6.9. боловсролын болон мэргэжлийн сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн эрхлэн гүйцэтгэж байгаа дүрэмд нь заасан боловсрол, мэргэжил олгох үйлчилгээ;

13.6.10.эрүүл мэндийн үйлчилгээ;
13.6.11.шашны байгууллагын үйлчилгээ;

13.6.12.Зайгсийн газар, түүний харьяа болон төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ;

13.6.13.Авто тээврийн тухай³ хуулийн 3.1.11-т заасан нийтийн тээврийн үйлчилгээ;

13.6.14.аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд гадаад улсын аялал жуулчлалын байгууллагатай гэрээ байгуулж жуулчдыг нь хүлээн авах, уг үйлчилгээг төлөвлөх, сурталчлах, бичиг баримтыг нь бүрдүүлэх зэргээр гадаадын жуулчдад үзүүлсэн /туроператор/ үйлчилгээ.

13.7.Жилийн 10.0 сая ба түүнээс доош төгрөгийн борлуулалтын орлоготой үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэгчид /импортлогчоос бусад/-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.

13.8. Эм, эм бэлдмэл, эмнэлгийн багаж, техник хэрэгсэл үйлдвэрлэх, худалдан борлуулахад энэ хуулийн 13.6.10 дахь заалт үйлчлэхгүй.

13.9.Энэ хуулийн 13.6.14-т заасан үйлчилгээнд жуулчдад үйлчлэх бааз, ресторан, жуулчин тээвэрлэх, газарчлах болон зочид буудлын үйлчилгээ хамаарахгүй.

13.10.Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, тэдгээрт ажиллагчдад энэ хуулийн 13.1.3-т заасан албан татварын чөлөөлөлтийг эдлүүлэхдээ, төлсөн албан татварыг нь буцаан олгох зарчмыг баримтална.

13.11.Бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэлийн дотоод эргэлтэд ашигласнаас бусад хэлбэрээр бусдад үнэ төлбөргүй шилжүүлсэн буюу хувийнхаа хэрэгцээнд ашигласан бол нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхгүй.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт, буцаан олголт

14 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварт хасалт хийх

14.1.Иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлснээсээ

хойшхи хугацаанд энэ хуулийн 7, 8, 11 дүгээр зүйлд заасны дагуу төлсөн дор дурдсан нэмэгдсэн өртгийн албан татварыг түүний төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татвараас хасч тооцно;

14.1.1.үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд төлсөн;

14.1.2. худалдах, түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар өөрөө шууд импортолсон бараа, ажил, үйлчилгээнд төлсөн;

14.1.3. нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдэх үед бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвартай нь хамт худалдан авсан бол үнийн дүнгээс төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасч;

14.1.4. мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, хуулийн этгээд өөрөө бэлтгэсэн буюу тариалсан бөгөөд үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, өндөг, арьс шир, үр тариаг дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнэд нь 10 хувийн нэмэгдсэн өртгийн албан татвар шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан этгээдийн төлөх нэмэгдсэн өртгийн албан татварыг уг хувиар хасч тус тус тооцно.

14.2.Энэ хуулийн 14.1.4-т заасан анхдагч түүхий эдийг импортолсон буюу худалдан авч зуучлан борлуулсан бол төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татвараас хасалт хийхгүй.

14.3.Худалдан авагч нь бэлтгэн нийлүүлэгчид нэмэгдсэн өртгийн албан татвар төлсөн нь нэхэмжлэл, падаан болон нягтлан бодох бүртгэлийн бусад баримтад тусгагдаагүй бол уг албан татварыг хасч тооцохгүй.

14.4. Дараахь бараа, ажил, үйлчилгээг импортлох, худалдаж авахад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг худалдан авагчийн төлөх уг албан татварын нийт дүнгээс хасахгүй;

14.4.1.суудлын автомашин, түүний эд анги, сэлбэг;

14.4.2.хувийн болон ажиллагчдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, үйлчилгээ;

14.4.3.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж импортолсон болон худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээ.

14.5.Суудлын авто машин, түүний эд анги, сэлбэгийг худалдан борлуулах үйл ажиллагааг эрхлэн явуулахаар өөрийнхөө гэрээ, дүрэмд тусган түүнийхээ дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдэд энэ хуулийн 14.4.1 дэх заалт үйлчлэхгүй.

³ Авто тээврийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

14.6 Энэ хуулийн 14.1-д заасны дагуу тухайн сард хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татварын дүнгээс их байвал татварын алба дараахь байдлаар зохицуулна:

14.6.1 дараагийн сар, улирал, жилд төлөх нэмэгдсэн өртгийн албан татварт шилжүүлэн тооцох;

14.6.2 хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөвт төлөх бусад төрлийн албан татварын төлбөрт шилжүүлэн тооцох.

14.7. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар импортолсон болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний зарим хэсгийг нь нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох, үлдсэн хэсгийг нь уг татвараас чөлөөлөгдөх үйлдвэрлэл, үйлчилгээнд буюу албан татвар ногдуулахгүй хэрэглээнд ашигласан бол зөвхөн нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигласан хэсгийг нь хасч тооцно.

15 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох

15.1. Илүү төлсөн, эсхүл хуульд заасан бол нэмэгдсэн өртгийн албан татварыг дор дурдсан журмаар албан татвар төлөгчид буцаан олгоно:

15.1.1 нэмэгдсэн өртгийн албан татварыг илүү төлсөн албан татвар төлөгч нь түүнийг буцаан авах хүсэлтээ татварын тооцоо хийж, тайлан тушаах үедээ харьяалах татварын албанд бичгээр гаргах;

15.1.2 энэ хуулийн 13.1.3-т заасан дипломат төлөөлөгчийн болон консулын газар, тэдгээрийн ажилтан тухайн сард дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан авах хүсэлтээ холбогдох баримтын хамт дараа сарын 10-ны дотор Үндэсний татварын ерөнхий газарт ирүүлэх;

15.1.3 харьяалах татварын алба энэ хуулийн 15.1.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногт багтаан хянаж, үлдэгдлийг нь баталгаажуулан, саналаа Үндэсний татварын ерөнхий газарт ирүүлэх;

15.1.4 Үндэсний татварын ерөнхий газар энэ хуулийн 15.1.2, 15.1.3-т зааснаар ирүүлсэн хүсэлт, саналыг хүлээн авснаасаа хойш ажлын 7 хоногт багтаан хянаж буцаан олгох татварын хэмжээг тодорхойлж, энэ тухайгаа албан татвар төлөгчид бичгээр мэдэгдэж, албан татвар төлөгчийн нэр, регистрийн дугаар, харилцагчийн баяны дансны дугаар, буцааж өгөх албан татварын хэмжээ, өрийн дүн зэргийг тодорхойлсон саналыг ажлын 2 хоногт багтаан санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

15.1.5 Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ

хуулийн 15.1.4-т заасан саналыг хүлээн авснаасаа хойш ажлын 45 хоногт багтаан татварыг буцаан олгох.

15.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.3 Буцааж олгох нэмэгдсэн өртгийн албан татвар нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн сар, улирал, жилд улсын төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 30 хувиас хэтрэхээргүй байна.

15.4 Энэ хуулийн 6.9-д заасан этгээд нь нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийлгэх буюу илүү төлсөн татварыг буцаан авах эрхтэй.

15.5 Өөрийнхөө үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортолсон бол албан татварыг сар бүр, бусад албан татвар төлөгчийн албан татварыг улиралд нэг удаа улсын төсвөөс буцаан олгоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төлөх, тайлагнах

16 дугаар зүйл. Бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах, төсөвт төлөх, тайлагнах

16.1 Албан татвар төлөгч нь бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг дор дурдсан журмаар дараа сарын 10-ны дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, батлагдсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана.

16.1.1 тухайн сард борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд ногдох албан татварыг албан татвар төлөгч өөрөө төсөвт төлөх;

16.1.2 Монгол улсын иргэн, хуулийн этгээд нь оршин суугч бус буюу Монгол Улсад байрладаггүй этгээдээс энэ хуулийн 7.3.5, 7.4.9-д заасан бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа нэмэгдсэн өртгийн албан татварыг уг бараа ажил, үйлчилгээний үнэ дээр нэмж авч төсөвт төлөх;

16.1.3 энэ хуулийн 7.3.4, 7.4.8-д заасан өрийн төлбөрт тооцогдох бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг тухайн төлбөр төлж байгаа этгээд төсөвт төлөх.

16.2 Импортын бараанд нэмэгдсэн өртгийн албан татварыг дор дурдсан журмаар ногдуулж тайлагнана.

16.2.1.гаалийн байгууллага энэ хуулийн 7.1.3, 8.1.1-т заасан импортын бараанд мөн хуулийн 9.1.1, 11.1-д заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулж, төсөвт төлүүлэх арга хэмжээ авах;

16.2.2.импортлогч нь энэ хуулийн 16.2.1-т заасны дагуу ногдуулсан татварыг төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлэх;

16.2.3.Улсын гаалийн ерөнхий газар нэмэгдсэн өртгийн албан татвар төлүүлсэн тухайн сарын тайланг дараа сарын 10-ны дотор, жилд тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор гаргаж санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

16.3.Энэ хуулийн 16.1-д заасан импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангийн маягыг Улсын гаалийн ерөнхий газрын дарга батална.

16.4. Импортын бараанд ногдуулж төлүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татварын талаар татварын албанаас шаардсан мэдээллийг гаалийн байгууллага тухай бүр гаргаж өгнө.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Хууль, тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

17 дугаар зүйл. Хууль, тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

17.1.Энэ хуулийн 6.1, 6.2-т заасны дагуу бүртгүүлбэл зохих иргэн, хуулийн этгээд харьяалах татварын албанд бүртгүүлж, гэрчилгээ авалгүйгээр бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, түүнчлэн ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бөгөөд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөөгүй байсан нь тогтоогдвол эрх бүхий улсын байцаагч

уг татварыг нөхөн төлүүлж дараахь хариуцлага хүлээлгэнэ:

17.1.1. нөхөн төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татварын нийт дүнгээс 0.3 хувиар тооцож хүү төлүүлэх;

17.1.2. нөхөн төлбөл зохих албан татварын дүнгийн 50 хувиас илүүгүй хэмжээгээр торгууль ногдуулах.

17.2.Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээндээ нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулаагүй буюу ногдуулсан боловч уг татварыг төлөөгүй нь тогтоогдвол эрх бүхий улсын байцаагч энэ хуулийн 17.1-д заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

17.3.Энэ хуулийн 6.1, 6.2-т заасны дагуу бүртгүүлж, гэрчилгээ авалгүйгээр бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, түүнчлэн ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бөгөөд тэдгээрт нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулсан боловч түүнийг төлөөгүй нь тогтоогдвол эрх бүхий улсын байцаагч татварыг нь нөхөн төлүүлж, энэ хуулийн 17.1.1-д заасан хүү болон нөхөн төлбөл зохих татварын дүнгээс илүүгүй хэмжээний торгууль ногдуулна.

АРАВДУГААР БҮЛЭГ

Бусад

18 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох.

18.1.Энэ хуулийг 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2006 оны 6 дугаар сарын 29-ны өдөр батлагдсан Нэмэгдсэн өртгийн

албан татварын тухай хууль/шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс буюу 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан дараахь хуулиудыг хүчингүй болсонд тооцугай:

1.1.Иргэний үнэмлэх хэвлэх материал, хэвлэлийн тоног төхөөрөмж, түүний

сэлбэг хэрэгслийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай Улсын Их Хурал 2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан хууль;

1.2. "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай Улсын Их Хурал

2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан хууль:

1.3. "Булган-Мөрөнгийн хооронд агаарын шилэн кабелийн дамжуулах сүлжээ байгуулах" төслийн хүрээнд импортоор нийлүүлэгдэх материал, тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай Улсын Их Хурал 2003 оны 10 дугаар сарын 09-ний өдөр баталсан хууль;

1.4. "Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн Оросын Холбооны Улсаас импортлож байгаа цахилгаан эрчим хүчийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай Улсын Их Хурал 2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан хууль;

1.5. Зарим материал, машин, механизм, тоног төхөөрөмж, бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай Улсын Их Хурал 2005 оны 8 дугаар сарын 4-ний өдөр баталсан хууль.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс буюу 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ЦНЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 10 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Хуулийн төслүүдийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 17.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2006 оны хаврын чуулганаар баталсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар татварын хэмжээг бууруулан улмаар татварын аливаа чөлөөлөл, хөнгөлөлтийг багасгасан, нөгөөтэйгүүр боловсрол, соёл, шинэчлэх ухааны салбарыг өөр арга хэлбэрээр дэмжих нь зүйтэй гэж үзэн Улсын Их Хурлын гишүүн

Б.Эрдэнэсүрэн, С.Ламбаа нараас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ЦНЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, банк өмч хувьчлал, тээвэр, эрчим хүч, хэвлэл мэдээлэл, мэргэжлийн хяналт, төр захиргааны

болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнаасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Цэнд-Акушийн Алимаа - Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн чанарын менежер
2. Ядамын Батчулуун - Төв аймгийн "Төв чандмань" дулаан, эрчим хүчний газрын халаалтын зуухны механик
3. Батхүүгийн Бунд - "Монгол Ньюс" ХХК-ийн реклам сурталчилгааны албаны дарга
4. Олзэвийн Ганцүү - Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн ерөнхий инженер
5. Очиржавын Дашням - Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн ажилтан

6. Бямбын Ерэнтэй - "Зууны мэдээ" сонины орлогч эрхлэгч
7. Бэгзжавын Жүгдэр - Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн ажилтан
8. Булууутын Нанзаддорж - Сангийн яамны хэлтсийн дарга
9. Чойжилын Санжаадорж - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны иргэн, ахмад ажилтан
10. Шилагарьдын Солонго - Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрлэх газрын хуулийн хэлтсийн дарга

11. Цэрэгцэгмидийн Хурц - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын хангалтын ахлах мэргэжилтэн
12. Сүрэнгийн Цэрэндорж - Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын дарга
13. Чойжилжавын Чадраабал - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны мэргэжилтэн
14. Долгорын Чулуунбаатар - Монголын

- сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхий нарийн бичгийн дарга
15. Пунцагдоржийн Шагдар - МОНЦАМЭ агентлагийн Москва хот дахь сурвалжлагч
16. Цэндийн Энхбат - ТВ-9 телевизийн ерөнхий захирал
17. Зандаахүүгийн Энхболд - Улсын Их Хурлын гишүүн

ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Жигдэнгомбын Сайнжаргал - Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын дарга, хурандаа

2. Бавуудоржийн Цогтбаяр - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын захиргаа удирдлагын газрын дарга

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Аюурын Алтанцэцэг - Нийслэлийн "Ханхайрхан" ХХК-ийн ерөнхий захирал
2. Маамуугийн Алтанцэцэг - Олон улсын монгол судлалын холбооны ерөнхий менежер
3. Сүрэнхорлоогийн Алтанцэцэг - Монголын өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч
4. Санжжавын Амарзаяа - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын авто баазын жолооч
5. Дондовын Амарсайхан - Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
6. Цэзсүрэнгийн Ариунаа - Орхон аймгийн Боловсрол, соёлын газрын дарга
7. Готовын Байгаль - Хөвсгөл аймгийн "Энхбулган" ХХК-ийн захирал
8. Цагааны Балжаа - Ховд аймгийн Жаргалант сум дахь "Гурвалжин холбоо" хоршооны дарга
9. Ноостойн Батаа - Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга
10. Баравын Батбилэг - "Зууны мэдээ" сонинны тоймч, албаны дарга
11. Сундуйн Батболд - Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
12. Тэрбишийн Батмөнх - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын мужаан
13. Шархүүгийн Батмөнх - "Өдрийн сонин"-ы албаны дарга, хариуцлагатай нарийн бичгийн дарга

14. Товчуугийн Батсуурь - Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Элчин сайдын яамны жолооч
15. Дүгэрсүрэнгийн Батчулуун - Нийслэлийн "СДБ трейд" компанийн захирал
16. Лувсандоржийн Баярмагнай - Монгол Ардын Хувьсгалт Намын Удирдах зөвлөлийн улс төрийн ажилтан
17. Цэвэлмалгийн Баярсайхан - Улсын Их Хурлын гишүүн
18. Хаянгаагийн Болорчулуун - Дорнод аймгийн "Дорнод гурил" ХХК-ийн захирал
19. Даваагийн Бямбажав - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч
20. Лүндэнгийн Бямбасүрэн - Завхан аймгийн Алдархаан сумын 8 жилийн дунд сургуулийн бага ангийн багш
21. Цэдээгийн Ванган - Завхан аймгийн Сонгино сумын малчин
22. Жамъянсэрэвийн Ванганжил - Завхан аймгийн Сонгино сумын Айраг нуур багийн малчин
23. Цэдэвийн Галсанжигмэд - Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газрын жолооч
24. Лүймэдийн Гансүх - Улсын Их Хурлын гишүүн
25. Төмөрбаатарын Гантөмөр - Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн сүлжээний газрын дарга
26. Цэдэнгийн Гарамжав - "Монполимет" ХХК-ийн ерөнхий захирал

27. Чойн Гомбосүрэн - Монголын хүүхдийн орны аж ахуйн дарга
28. Аюурын Даваа - Увс аймгийн Улаангом сумын 7 дугаар багийн иргэн, ахмад ажилтан
29. Төмөрбатын Дашням - "Өдрийн сонин"-ы Тамгын газрын дарга
30. Шандангийн Дашсүрэн - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын сувилагч, бага эмч
31. Аюушийн Должмаа - Говь-Алтай аймгийн Дөрви сумын дунд сургуулийн захирал
32. Бандийн Доржсүрэн - Дорноговь аймгийн Сайхандулаан сумын "Гурванхяргуй" ХХК-ийн Мэлын эмч
33. Гоохүүгийн Дүнчээ - Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын дунд сургуулийн хими-биологийн багш
34. Найдангийн Дэлгэрмаа - Дундговь аймгийн "Мөнхдэлгэр" хувийн эмнэлгийн тогооч
35. Цэгмэдийн Жавзан - Эрүүл мэнд шинжлэх ухааны их сургуулийн харьяа Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны коллежийн багш
36. Чойжилсүрэнгийн Жаргалсайхан - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын авто баазын жолооч
37. Даринхүүгийн Жигжид - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны өндөр настан, ахмад ажилтан
38. Сосорбарамын Занаа - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын өндөр настан, ахмад ажилтан
39. Буныагийн Мижид - Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн диспансерын эрхлэгч
40. Тогоочийн Мөнхор - Нийслэлийн брокер, дилерийн "Алтан Хоромсог" ХХК-ийн гүйцэтгэх захирал
41. Цэндийн Мөнх-Оргил - Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга
42. Галбадрахын Намсрай - Говь-Алтай аймгийн "Арвин бэлт" ХХК-ийн мужаан, кранчин
43. Базаржавын Нацагдорж - Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн программын хэлтсийн дарга
44. Сэнгийн Норов - Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн зүү төөнүүрийн эмчилгээний их эмч
45. Шагжаагийн Норовбүжид - Монголын Өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч
46. Ломбын Норовсүрэн - Монгол Улсын их сургуулийн сэтгүүл зүйн тэнхмийн багш
47. Гэндэнжавын Нямдаваа - Ховд аймгийн Засаг дарга
48. Гончигийн Нямхүү - Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн шүдний техникч
49. Дүрээгийн Одохуу - Улсын Их Хурлын гишүүн
50. Цэрэндоржийн Отгонбаатар - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Засаг дарга
51. Гомбожавын Отгонбаяр - "Зууны мэдээ" сонины албаны дарга
52. Дэмчигжавын Отгонбаяр - "Зууны мэдээ" сонины албаны дарга, хариуцлагатай нэрийн бичгийн дарга
53. Төгсөөгийн Оюунбилэг - Нийслэлийн "Номун далай" коллежийн захирал
54. Намжирын Оюунчимэг - "Өнөөдөр" сонины Реклам сурталчилгааны албаны дарга
55. Бизьяагийн Пүрэв - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа Засгийн газрын 10 дугаар байрны зохион байгуулагч
56. Дүгэржавын Пүрэв - Дархан-Уул аймгийн Монгол Ардын Хувьсгалт Намын хорооны ахмад ажилтан
57. Мэндбаярын Пүрэв - Дархан-Уул аймгийн Анчдын нийгэмлэгийн гишүүн, өндөр настан
58. Готовын Рэнчинханд - Завхан аймгийн Булнай сумын 10 жилийн сургуулийн бага ангийн багш
59. Кадрын Сайраан - Улсын Их Хурлын гишүүн
60. Үржингийн Сангидорж - Улаанбаатар төмөр замын Дорноговь аймгийн Замын-Үүд өртөөний зорчигч тээвэр эрхэлсэн орлогч дарга
61. Цагааны Санчин - Түлш эрчим хүчний яамны Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн ахлах мэргэжилтэн
62. Дашдэндэвийн Сарангэрэл - Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн найруулагч
63. Түдэвийн Содномбор - Ховд аймгийн Чандмань сумын Засаг дарга
64. Мишигийн Сономпил - Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд
65. Сараагийн Сүгир - Өмнөговь аймгийн Гурвангэс сумын малчин
66. Пэрэнлэйн Сэрсмаа - Нийслэлийн Аудитын газрын аудитор

67. Нанзадын Туул - МОНЦАМЭ агентлагийн хэвлэх цехийн мастер
68. Дамбын Туяа - Дорнод аймгийн Тээвэр зохицуулалтын албаны дарга
69. Лааганы Төмөрбаатар - Хөвсгөл аймгийн "Хөвсгөл геологи" ХК-ийн ерөнхий захирал
70. Синваазын Төмөрхүү - Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга
71. Шоотонгийн Төрбат - Дундговь аймгийн Засаг дарга
72. Равдангийн Тэгшжаргал - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа Төрийн ордны зоогийн газрын тогооч
73. Дэндэвийн Тэрбишдагва - Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайд
74. Гаадангийн Уламбаяр - "Шихихутаг" хууль зүйн дээд сургуулийн сургалтын албаны дарга
75. Арвинбуянгийн Уртнасан - "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн Баянхонгорын хэсгийн диспетчер
76. Самбуугийн Хандсүрэн - Төрийн ордны эмийн сангийн эрхлэгч
77. Мөнхбаярын Хувцагаан - Монголын өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч
78. Ухнаагийн Хүрэлсүх - Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд
79. Даваахүүгийн Цовоо - Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлэгч
80. Бямбаагийн Цогтбаяр - Нийслэлийн "Зохиомж" дээд сургуулийн захирал
81. Самандарийн Цогтбаяр - "Тоншуул" сэтгүүлийн ажилтан, шог зураач

82. Өвгөний Цэнд - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын уран хатгамалч
83. Цэдэн-Ишийн Цэнд-Аюуш - Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хорооны Засаг дарга
84. Норовын Цэрэнханд - Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын Үйлчилгээ, аж ахуйн газрын хэлтсийн дарга
85. Шоовдойн Цэцгээ - Нийслэлийн 35 дугаар цэцэрлэгийн нягтлан бодогч
86. Бажинзын Чимэддорж - Завхан аймгийн Алдархаан сумын 8 жилийн дунд сургуулийн багш
87. Мэнэрэлийн Чимэдцэцэ - МОНЦАМЭ агентлагийн "Мэнгу Шяоши Бао" сонин эрхлэгч
88. Баянсангийн Шалхаан - Говь-Алтай аймгийн Алтай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
89. Райбысын Шерикбай - Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын ахлах сургуулийн зөвлөх багш
90. Цэдэвдоржийн Энхбат - Төв аймгийн Засаг дарга
91. Жамсрангийн Энхбаяр - Баянхонгор аймгийн "Номун далай" цогцолбор сургуулийн захирал
92. Доржсүрэнгийн Энхбаяр - Нийслэлийн татварын газрын улсын байцаагч
93. Бямбадоржийн Энхболд - Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч
94. Раднаагийн Энхтуяа - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын авто баазын ерөнхий нягтлан бодогч
95. Цэрэндоржийн Эрдэнэчулуун - Үйлдвэр, худалдааны яамны ахлах мэргэжилтэн
96. Санжидын Южирмаа - Монголын Өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Пүрэвийн Ихзаая - Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвийн дарга, хурандаа
2. Доржийн Сайнболд - Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

3. Лхашиднямын Содномдорж - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын хэлтсийн дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Сугарын Алтанхуяг - Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн уурхайн ерөнхий инженер
2. Содномпилийн Алтанцэцэг - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн нягтлан бодогч

3. Лувсан-Осорын Алтанцэцэг - Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын хуулийн зөвлөх
4. Сэрээгийн Алтантуяа - Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл

5. Жамсрангийн Амгалан - Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн барилгын материалын багш
6. Даваадоржийн Ариунаа - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа Амралт үйлчилгээний цогцолборын ахлах менежер
7. Санжаагийн Аюурзана - Монгол Улсаас Бүгд Найрамдах Финланд Улсад суугаа Элчин сайдын яамны жолооч
8. Раднаабазарын Баасанжав - Үндэсний статистикийн газрын Үндэсний тооцоо, аргачлал, судалгааны газрын мэргэжилтэн
9. Норовпилийн Баатар - Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Элчин сайдын яамны жолооч
10. Мишигдоржийн Байгалмаа - Хэнтий аймгийн "Хэнтий-Ус" ХХК-ийн ерөнхий санхүүч
11. Оюунгэрэлийн Байгалмаа - Үндэсний статистикийн газрын Статистикийн төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн
12. Норовын Батсайхан - Баянхонгор аймгийн "Баянхонгор-эрчим хүч" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ээлжийн ахлагч
13. Дашийн Батсайхан - Баянхонгор аймгийн "Баянхонгор-эрчим хүч" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын харуул
14. Баатарсүрэнгийн Баярмаа - Үндэсний статистикийн газрын Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын ахлах мэргэжилтэн
15. Далхжавын Баттөр - Дархан-Уул аймгийн Залуучууд театрын бүжигчин
16. Лувсандоржийн Баяраа - Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн газрын дарга
17. Сэдэнгийн Буянжаргал - Говь-Алтай аймгийн Алтай сумын малчин
18. Ентонгийн Бүд - Өмнөговь аймгийн Сэврэй сумын малчин
19. Ядамсүрэнгийн Бямбажав - Дорноговь аймгийн Замын-Үүд сумын эмнэлгийн өрхийн эмч
20. Цэдэндоржийн Бямбанэрэн - Хэнтий аймгийн "Хэнтий хангай" ХХК-ийн мастер, бригадын дарга
21. Дамчээгийн Ганбат - Өмнөговь аймгийн "Тавантолгой" ХК-ийн кразын жолооч
22. Еягбжаарын Ганбат - Монгол Улсаас Бүгд Найрамдах Унгар Улсад суугаа Элчин сайдын яамны жолооч
23. Дамдингийн Ганболд - Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын жолооч
24. Удвалын Гантөмөр - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа Засгийн газрын 4 дүгээр байрны сантехникч
25. Дамбын Гантөмөр - Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн механик засварын халуун төмөрчин
26. Навааны Готов - Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
27. Цэдэнжанцангийн Гүргэл - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа Засгийн газрын 4 дүгээр байрны нярав
28. Нямсүрэнгийн Даваадорж - Сэлэнгэ аймгийн Баянгол сумын байгаль хамгаалагч
29. Доржийн Дамба - Түвш эрчим хүчний яамны ахлах мэргэжилтэн
30. Заяатын Дамдиндорж - "Зууны мэдээ" сонины албаны дарга
31. Дамдингийн Дарьжав - Говь-Алтай аймгийн Төгрөг сумын малчин
32. Доржийн Долгоржав - Говь-Алтай аймгийн Тонхил сумын Цаг уурын станцад цаг уурын техникч
33. Галсангийн Доржсүрэн - Хэнтий аймгийн Дадал сумын "Сэргээхүй" бүрэн бус нөхөрлөлийн ажилтан
34. Ганжингийн Дүгэрээ - Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яамны жолооч
35. Найдангийн Дэлгэрсуурь - Хэнтий аймгийн Дархан сумын нийгмийн даатгалын байцаагч
36. Сайханы Жаниль - Дархан-Уул аймгийн "Дулаан Шарын гол" ХК-ийн ерөнхий менежер
37. Доржийн Жаргалсайхан - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын орлогч
38. Сэтэвийн Жигжид - Монгол Улсаас Бүгд Найрамдах Дани Улсад суугаа Элчин сайдын яамны жолооч
39. Шапихын Зейнезайв - Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын 11 жилийн сургуулийн бага ангийн багш
40. Цэрмаагийн Ичинхорлоо - МОНЦАМЭ агентлагийн аж ахуйн нярав
41. Сэндэнгийн Ичинхорол - Өмнөговь аймгийн Сэврэй сумын малчин

42. Сараагийн Лхагва - Өмнөговь аймгийн Гурвантэс сумын малчин
43. Сангидоржийн Лхагва - Баянхонгор аймгийн "Баянхонгор эрчим хүч" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын краны жолооч
44. Доржийн Лхагвадорж - Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч
45. Чүлтэмийн Мөнхбазар - Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Суварга-Эв" ХХК-ийн барилгын даамал
46. Төмөр-Очирын Мягмар - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын үйлчлэгч
47. Зундуйн Нансалмаа - Үндэсний статистикийн газрын Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын ахлах мэргэжилтэн
48. Чимэдбалжирын Нарангэрэл - Төр, засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа Хэвлэх үйлдвэрийн тигелийн хэвлэгч
49. Дамдингийн Нарангэрэл - Төр, засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын авто баазын тэнхлэг тохиргоочин, жолооч
50. Доржийн Нарангэрэл - Эрүүл мэндийн яамны халдварт өвчний сэргийлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн
51. Логийсүрэнгийн Ника - Говь-Алтай аймгийн Холбооны газарт техник, үйлчилгээний албаны дарга
52. Амаахүүгийн Норсмаа - Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газрын засалчин
53. Хасын Отгонбат - Түлш эрчим хүчний яамны бичиг хэргийн эрхлэгч
54. Хишигтийн Отог - Увс аймгийн барилга угсралтын "Ундрах бүтээмж" ХХК-ийн гүйцэтгэх захирал
55. Мангалсүрэнгийн Оюунжаргал - Үндэсний статистикийн газрын Статистикийн төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн
56. Тилехуны Рашила - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 1 дүгээр цэцэрлэгийн багш
57. Женисханы Роза - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ахлах сургуулийн байрны багш
58. Мятраазын Рэгээдмаа - Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, байгаль орчны шинжилгээний төвийн захирал
59. Дарьсүрэнгийн Сандаг - Улаанбаатар төмөр замын Сайншанд дахь замын 4 дүгээр ангид замын ахлах мастер
60. Түдэвийн Сарангэрэл - Дорноговь аймгийн Замын-Үүд боомтын хилийн мэргэжлийн хяналтын албаны лаборант
61. Бямбын Саранчимэг - Үндэсний статистикийн газрын Аргачлал шинжилгээ судалгааны газрын ахлах мэргэжилтэн
62. Цэрэнхүүгийн Сосорбарам - Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын дунд сургуульд зайны сургалтын арга зүйч
63. Бэхийн Сосорбурам - Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын "Номин хөх" хоршооны дарга
64. Чойжилийн Сэлэнгэ - Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газрын нярав
65. Халелийн Тахыр - Баян-Өлгий аймгийн Толбо сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
66. Лхагваагийн Тунгалаг - "Зууны мэдээ" сонинь сурвалжлагч, албаны дарга
67. Цагааны Тэгшжаргал - Үндэсний статистикийн газрын Статистикийн төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн
68. Гошгойгийн Ундармаа - Говь-Алтай аймгийн Алтай хотын Захирагчийн ажлын албаны дарга
69. Очирхүүгийн Хишигбуян - Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны 11 жилийн сургуулийн биеийн тамирын багш
70. Хандын Хонгор - Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч
71. Дамдингийн Цолмон - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын үйлчлэгч
72. Моломын Цэвээнжав - Увс аймгийн "Увс Арвижих" ХХК-ийн зөвлөх инженер
73. Өлзийхутагийн Цээнпил - Говь-Алтай аймгийн барилгын "Харшийн цуурай" компанийн захирал
74. Намнандоржийн Цэнд-Аюуш - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа Засгийн газрын 3 дугаар байрны үйлчлэгч
75. Дашдоржийн Цэцэгдулам - Хэнтий аймгийн "Оч Манлай" ХХК-ийн инженер
76. Чадраабалын Цээрэгээн - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 11 жилийн 2 дугаар сургуулийн хичээлийн эрхлэгч
77. Балдансанжаагийн Чимэддорж - Хэнтий аймгийн Дадал сумын Онон Балжгийн байгалийн цогцолборт газрын салбарын эрхлэгч

78. Сахитханы Шаймурат - Баян-Өлгий аймгийн Цагдаагийн хэлтсийн ажилтан
79. Базарсадын Ширчинсүрэн - Дархан-Уул аймгийн "Урд-Эх" ХХК-ийн малын эмч
80. Тогтвойн Шофёр - Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн орлогч захирал
81. Дамдингийн Шүрэнбат - Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх зөвлөлийн нарийн бичгийн дарга
82. Дэмбэрэлийн Энхбаатар - Увс аймгийн "Сэд Мандах" ХХК-ийн дэд захирал
83. Аюурааны Энхбаяр - Хэнтий аймгийн Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
84. Балсангийн Энхтуяа - "Зууны мэдээ" сонины албаны дарга

85. Ламжавын Энхтуяа - Өмнөговь аймгийн хувийн хэвшлийн "Хүнлэг говь" эмнэлгийн захирал
86. Жамаагийн Эрдэнэбат - Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн ерөнхий технологич
87. Цэрэнгийн Эрдэнэбаяр - Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын сантехникч
88. Нанжидын Эрдэнэчимэг - МОНЦАМЭ агентлагийн техникийн хэлтсийн дарга
89. Шаравын Эрдэнэчимэг - МОНЦАМЭ агентлагийн сурвалжлагч
90. Намсрайн Янжин - Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газрын жолооч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 8 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

"Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг тогтоох тухай" Засгийн газрын 2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 15 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "Хотын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс" гэснийг "Хотын хөгжлийн бодлогын хэлтэс", 2 дугаар зүйлийн "Хот тохижилтын хэлтэс" гэснийг "Хот, нийтийн аж ахуйн хэлтэс", 4 дүгээр зүйлийн 4 дэх заалтад "Байгаль хамгаалах газар" гэснийг "Байгаль

хамгаалах газар /Агаарын чанарын албатай", 4 дүгээр зүйлийн 5 дахь заалтад "Боловсрол, шинжлэх ухааны газар" гэснийг "Боловсролын газар", 4 дүгээр зүйлийн 12 дахь заалтад "Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн" гэснийг "Тээврийн газар", 4 дүгээр зүйлийн 14 дэх заалтад "Хөрөнгө оруулалтын газар" гэснийг "Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

С.БАТБОЛД

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хүг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265058
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2